

31

“Радио телевизийн үндэсний сүлжээ”  
Улсын төсөвт үйлдвэрийн газрын  
захирлын 2023 оны дугаар  
тушаалын нэгдүгээр хавсралт

## АЛБАН ХААГЧДАД ҮР ДҮНГИЙН НЭМЭГДЭЛ ОЛГОХ ЖУРАМ

### НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Энэхүү журам нь албан хаагчдын ажлын чанар, үр дүнг бодитой үнэлж, идэвх санаачлагыг дээшлүүлэхэд оршино.

Тус газрын орон нутаг дахь газар, салбар, хэлтэс, албаны нийт албан хаагчдад ажлын үр дүнг үнэлж, нэмэгдэл олгоход энэхүү журмыг мөрдлөг болгоно.

### ХОЁР.АЖЛЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

2.1 Үүрэгт ажлаа мэргэжлийн түвшинд гүйцэтгэж, тухайн сардаа үр бүтээлтэй ажилласан албан хаагчид үр дүнгийн нэмэгдэл олгоно.

2.2 Сар бүрийн ажлын тайлангаа дараа сарын 05-ны өдрийн дотор газар салбар, хэлтэс, албаны даргадаа танилцуулж, дүгнүүлснээр ажлын үр дүнгийн нэмэгдэл сар бүрийн 28-ны өдрийн цалин дээр олгогдоно.

2. Хөлсөөр ажиллах гэрээ болон, төсөвт байгууллагын ажил үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэж байгаа ажилтанд үр дүнгийн нэмэгдэл олгохгүй.

2.4 Сар бүрийн үр дүнгийн нэмэгдэл нь ажилтны тухайн сарын бодогдсон цалингийн 15 /арван тав / хүртэл хувь байна.

2.5 Үр дүнгийн нэмэгдлийг тухайн албан хаагчийн ажлын цаг ашиглалт /хоцролт, таслалт/, ажлын ачаалал, үүрэг даалгаврын биелэлт, шинэ санал, санаачлага, ажлын тайлан болон хавсралтаар баталсан шалгуур үзүүлэлтийн дагуу дүгнэнэ. Дүгнэхдээ тухайн шалгуур үзүүлэлтэд заасан ажлыг хангалттай гүйцэтгэсэн гэж үзсэн тохиолдолд оноог бүрэн олгох, дутуу гүйцэтгэлтэй гэж үзвэл оноог гүйцэтгэлээс хамаарч хувилж тооцох, хангалтгүй гэж үзвэл 0 оноогоор дүнгэх хэлбэрээр үнэлнэ.

2.6 Албан хаагчдын ажлын үр дүнг газар, салбар, хэлтэс, албаны дарга шалгуур үзүүлэлтийн дагуу дүгнэж, цалингийн цагийн тодорхойлолтын хамт холбогдох албан тушаалтанд хүргүүлнэ.

2.7 Тус газрын хэлтэс, албаны даргын ажлын үр дүнг газрын захирал дүгнэх бөгөөд газрын захирлын эзгүйд захиргаа удирдлагын хэлтэс дүгнэнэ.

2.8 Орон нутаг дахь газар болон хот орчмын салбарын дарга нарын үр дүнг Захиргааны удирдлагын хэлтэс, Техникийн хэлтэс, Шуурхай удирдлагын хэлтэс, Санхүүгийн хэлтэс, Хяналт, шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга нар тус бүрийн хариуцсан чиглэлийн дагуу /хавсралтаар баталсан шалгуур үзүүлэлт/ дүгнэх бөгөөд түүнийг нь газрын захирал батална.

### ГУРАВ.БУСАД

3.1 Үр дүнгийн нэмэгдлийг дараах тохиолдолд олгохгүй. Үүнд:

- 3.1.1 Тухайн сарын ажилласан цаг нь 70 хувиас доош бол;
- 3.1.2 Тухайн сард ээлжийн амралттай /өвчтэй, чөлөөтэй/ бол;

3.2 Үр дүнг бодитой бус дүгнэсэн тохиолдолд Захиргааны удирдлагын хэлтсийн дарга хянаж, дахин үнэлэх эрхтэй.

---Оо---